



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/144/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт	12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.6.3 Нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	13
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	14
4.2.1 Залруулсан алдаа.....	14
4.2.2 Төлбөрийн акт.....	14
4.2.3 Албан шаардлага	14
4.2.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

1.Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

дод.02.02 № 1302/140
танай _____-ны № _____-т

ТҮДЭВТЭЙ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ж.НАЛЖИРМАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- ✓ Бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтгүй, орлогод бүртгэхдээ анхан шатны баримтад үндэслээгүй, баримтын үнэн зөвийг нягтлаагүй
- ✓ Бараа материалын тооллогыг хууль, журмын дагуу хийж гүйцэтгээгүй, тооцоо бодсон актыг буруу үйлдсэн, дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас хүнсний материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд 8.6 сая төгрөгийн хүнсний материалыг дутагдуулсан
- ✓ Албан томилолт, цалин хөлсийг 0.7 сая төгрөгөөр илүү тооцож олгосон
- ✓ 10.8 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангагдаагүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан

013020084

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, гэсэн заалтуудтай нийцээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>45,313.68</u>	<u>55,882.40</u>
33	АВЛАГА	-	8,595.40
335	Бусад авлага	-	8,595.40
3351	Байгууллагаас авах авлага	-	4,295.50
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	4,299.90
35	БАРАА МАТЕРИАЛ	45,313.68	47,287.00
351	Түүхий эд материал	4,285.00	5,940.15
35110	Тусгай зориулалттай материал	3,285.00	3,285.00
35130	Эм боох материал	1,000.00	2,655.15
354	Хангамжийн материал	41,028.68	41,346.85
35410	Бичиг хэргийн материал	716.70	1,788.20
35420	Аж ахуйн материал	2,378.20	2,118.62
35440	Түлш, шатах тослох материал	1,050.00	-
35450	Барилгын засварын материал	522.20	748.60
35460	Хүнсний материал	9,708.66	9,004.67
35470	Бусад хангамжийн материал	26,652.92	27,686.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,122.46</u>	<u>62,964.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	67,122.46	62,964.22
392	Биет хөрөнгө	60,356.46	56,198.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	57,303.91	57,303.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,554.08)	(27,804.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,483.08	23,474.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,916.30)	(11,203.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,648.60	12,648.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,234.43)	(10,981.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,206.76	30,206.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,355.07)	(18,220.54)
39217	Ном	774.00	774.00
393	Биет бус хөрөнгө	6,766.00	6,766.00
39301	Програм хангамж	1,650.00	1,650.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,116.00	5,116.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>112,436.14</u>	<u>118,846.62</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>112,436.14</u>	<u>118,846.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	112,436.14	118,846.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,209.43	44,209.43
51101	Өмч: - төрийн	44,209.43	44,209.43
512	Хуримтлагдсан үр дүн	11,764.77	18,175.25
51210	Өмнөх үеийн үр дүн	11,764.77	11,764.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,410.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,461.94	56,461.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>112,436.14</u>	<u>118,846.62</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	237,076.77	212,486.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,499.00	559.24
120	Нийтлэг татварын бус орлого	3,499.00	559.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499.00	559.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499.00	559.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	233,577.77	211,927.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	200,854.00	195,976.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,854.00	195,976.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,195.07	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,195.07	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,528.70	15,951.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,528.70	15,951.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,384.55	206,076.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448.20	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,669.63	186,767.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,815.39	124,815.43
210101	Үндсэн цалин	91,176.76	81,065.67
210102	Нэмэгдэл	32,032.45	34,737.19
210104	Урамшуулал	4,606.18	9,012.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,981.22	16,258.43
210201	Тэтгэврийн даатгал	10,781.17	10,820.63
210202	Тэтгэмжийн даатгал	1,268.50	1,262.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,140.84	1,010.22
210204	Ажилгүйдлийн даатгал	253.70	249.06
210205	Эрүүл мэндийн даатгал	2,537.01	2,915.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,496.44	15,467.00
210302	Түлш, халаалт	12,957.00	15,467.00
210303	Цэвэр, бохир ус	91.24	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,637.05	5,898.14
210401	Бичиг хэрэг	313.44	604.00
210402	Тээвэр, шатахуун	387.60	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	657.38	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	278.63	5,294.14
2105	Нормативт зардал	13,294.72	8,359.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182.00	671.80
210502	Хоол, хүнс	13,112.72	7,687.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30.50	967.60
210604	Урсгал засвар	30.50	967.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550.00	-

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,864.33	15,001.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	532.00	1,851.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,332.33	13,150.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,714.91	19,308.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,095.07	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,095.07	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,619.84	19,308.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,619.84	19,308.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,307.78)</u>	<u>6,410.48</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(1,307.78)</u>	<u>6,410.48</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,209.4	56,461.9	11,764.8	112,436.1
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,209.4	56,461.9	11,764.8	112,436.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,209.4	56,461.9	11,764.8	112,436.1
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	6,410.5	6,410.5
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,209.4	56,461.9	18,175.3	118,846.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>233,577.77</u>	<u>211,927.40</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	233,577.77	211,927.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	200,854.00	195,976.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,854.00	195,976.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,195.07	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,195.07	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,528.70	15,951.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,528.70	15,951.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>231,127.77</u>	<u>202,935.60</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	231,127.77	202,935.60

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,412.86	183,626.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,815.39	124,815.43
210101	Үндсэн цалин	91,176.76	81,065.67
210102	Нэмэгдэл	32,032.45	34,737.19
210104	Урамшуулал	4,606.18	9,012.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,981.22	16,258.43
210201	Тэтгэврийн даатгал	10,781.17	10,820.63
210202	Тэтгэмжийн даатгал	1,268.50	1,262.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,140.84	1,010.22
210204	Ажилгүйдлийн даатгал	253.70	249.06
210205	Эрүүл мэндийн даатгал	2,537.01	2,915.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,007.44	15,275.87
210301	Гэрэл, цахилгаан	609.20	743.77
210302	Түлш, халаалт	13,307.00	14,417.00
210303	Цэвэр, бохир ус	91.24	115.10
2104	Хангамж, бараа материалын зардал	3,111.23	3,797.69
210401	Бичиг хэрэг	351.34	1,375.00
210402	Тээвэр, шатахуун	387.60	196.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	657.38	735.40
210404	Ном, хэвлэл	-	48.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,714.91	1,443.09
2105	Нормативт зардал	16,165.59	20,185.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,182.00	2,581.25
210502	Хоол, хүнс	12,983.59	15,578.74
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.00	2,026.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	581.50
210604	Урсгал засвар	-	581.50
2107	Томилолт, зочны зардал	-	1,100.00
210702	Дотоод албан томилолт	-	1,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550.00	640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	640.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	782.00	971.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	782.00	971.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,714.91	19,308.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,095.07	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,095.07	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,619.84	19,308.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,619.84	19,308.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,450.00</u>	<u>8,991.80</u>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,450.00	8,991.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,450.00	8,991.80
2200	Дотоод эх үүсвэрээр	2,450.00	8,991.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,450.00	8,991.80
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,450.00)</u>	<u>(8,991.80)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	222,884.00	211,927.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222,884.00	211,927.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	222,884.00	192,618.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	136,633.20	124,815.43
210101	Үндсэн цалин	91,392.80	81,065.67
210102	Нэмэгдэл	35,018.20	34,737.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500.00	-
210104	Урамшуулал	9,722.20	9,012.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,445.60	16,258.43
210201	Тэтгэврийн даатгал	12,980.20	10,820.63
210202	Тэтгэмжийн даатгал	1,366.30	1,262.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,093.10	1,010.22
210204	Ажилгүйдлийн даатгал	273.30	249.06
210205	Эрүүл мэндийн даатгал	2,732.70	2,915.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,356.60	15,275.87
210301	Гэрэл, цахилгаан	1,800.00	743.77
210302	Түлш, халаалт	22,756.60	14,417.00
210303	Цэвэр, бохир ус	800.00	115.10
2104	Хангамж, бараа материалын зардал	5,516.50	3,825.69
210401	Бичиг хэрэг	1,377.60	1,375.00
210402	Тээвэр, шатахуун	1,595.70	224.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700.00	735.40
210404	Ном, хэвлэл	103.30	48.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,739.90	1,443.09
2105	Нормативт зардал	30,602.60	20,157.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,582.00	2,581.25
210502	Хоол, хүнс	25,987.40	15,550.74
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,033.20	2,026.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	594.40	581.50
210604	Урсгал засвар	594.40	581.50

2107	Томилолт, зочны зардал	1,549.90	1,100.00
210702	Дотоод албан томилолт	1,549.90	1,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	929.90	640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	929.90	640.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,255.30	9,963.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,255.30	9,963.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	19,308.79
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	19,308.79
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	19,308.79
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	222,884.00	211,927.40
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	196,933.00	195,976.40
131001	Улсын төсвөөс санхүүжих	196,933.00	195,976.40
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,951.00	15,951.00
132001	Орон нутгийн төсвөөс	25,951.00	15,951.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.011	0.011
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.006	0.006
620003	Үйлчлэх ажилтан	0.004	0.004

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 07-ны өдрийн №01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг асран хамгаалах хүмүүжүүлэх сурах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг

дэмжих өсөх хүмүүжүүлэх сурах таатай орчин бүрдүүлэн сургуульд бэлтгэхэд оршино. Сургуулийн өмнөх боловсролыг хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмжийг мөрдөх сургалтын чанарыг сайжруулах эрүүл аюулгүйн шаардлагыг хангаж эрүүл хоол хүнсээр хангах гэсэн зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү үйл ажиллагаандаа дагаж мөрддөг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрддөггүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 222.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	8,595.40	8,595.40
Бараа материал	45,313.68	47,287.00	1,973.32
Үндсэн хөрөнгө	67,122.46	62,964.22	(4,158.24)
Нийт хөрөнгө	112,436.14	118,846.62	6,410.48
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	112,436.14	118,846.62	6,410.48
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	112,436.14	118,846.62	6,410.48

Авлага дансны үлдэгдэл 8.6 сая төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага 4.3 сая төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага 4.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.97 сая төгрөгөөр өссөн нь 42.5 сая төгрөгийг бараа материал худалдан авч, 0.57 сая төгрөгийн хангамжийн материалыг үнэ төлбөргүй бэлтгэсэн бөгөөд 32.5 сая төгрөгийн бараа материал үйл ажиллагаандаа зарцуулж, аудитын явцын хяналтын тооллогоор 8.6 сая төгрөгийн хүнсний материал дутагдсаныг хасалт хийж акт тогтоосон зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4.2 сая төгрөгөөр буурсан нь дээд шатны байгууллагын шийдвэрээр 9.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, 13.2 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 26.0 сая, улсын төсвөөс 197.0 сая, нийт 223.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 223.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 195.98 сая, орон нутгийн төсвөөс 15.95 сая, нийт 211.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 192.6 сая төгрөгийг зарцуулж, 19.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилт байхгүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дээд шатны байгууллагын шийдвэрээр 9.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу үнэн зөв мэдээлээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Хөрөнгө оруулалт, худалдан авалтын 5 саяас дээш үнийн дүн бүхий мэдээг өссөн дүнгээр мэдээлээгүй, цалингаас бусад 5 сая төгрөгийн зардлыг буруу мэдээлсэн, хөрөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлдэггүй зэрэг алдаа зөрчил илэрлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд шилэн дансны мэдээллийг сайжруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2020 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгөд бүртгэлтэй Си Ти Эс санхүүгийн программын ашиглалтын давуу болон сул талыг одоогийн программтай харьцуулан дүгнэлт гаргаж, дээд шатны байгууллагад хандан шийдвэрлэж зохих арга хэмжээг авч ажилласан эсэхийг шалгах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 41.24 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19.09 сая төгрөгийн алдааг залруулж, 9.26 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 2.03 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10.86 сая төгрөгийн алдаанд зөвлөмж хүргүүллээ.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 36.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

- ✓ 0.49 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн.
- ✓ Санхүүжилтийн орлого болон төвлөрүүлэх шилжүүлгийг 10.0 сая төгрөгөөр илүү тусгасан.
- ✓ Бараа материалын үлдэгдэлд аудитын явцад хяналтын тооллого хийхэд 8.6 сая төгрөгийн үнэ бүхий мах, хүнсний материал дутагдсан.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, УСНББОУС 2 Мөнгөн гүйлгээний тайлан, УСНББОУС 12 Бараа материал зэрэг стандартуудтай нийцээгүй, үнэлгээ ба хувиарлалт, үнэн зөв байх, оршин байх батламж мэдээдлийг хангаагүй тул тайланг засварлуулсан.

4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ Хяналтын тооллогоор 8.6 сая төгрөгийн бараа материалыг дутагдуулсан.
- ✓ Нягтлан бодогчийн цалингаас 0.24 сая төгрөгийн ХХОАТ дутуу суутгасан.
- ✓ Томилолтын тооцоонд 0.06 сая төгрөгийн буудлын мөнгө давхардуулан олгосон.
- ✓ Ажилчдын ээлжийн амралтын цалингаас 0.36 сая төгрөгийн татвар, НДШ дутуу суутгасан.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.7, 4.2.3.3, 4.2.3.5 заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

4.2.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

- ✓ Ажилтнуудад 2.0 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр нормын хувцас худалдан авч олгосон.
- ✓ Өмнөх оны аудитаар шилэн дансны мэдээллийг сайжруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдааг давтан гаргасан.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43 дугаар тогтоол, өмнөх аудитын зөвлөмж зэргийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ Түүвэрт хамрагдсан ажил гүйлгээнээс 10.9 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэг	10	41.24	3	19.09	4	9.26	2	2.03	1	10.86
Дүн		10	41.24	3	19.09	4	9.26	2	2.03	1	10.86